



**АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ 2025 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025 оны 12 дугаар сарын 20

Хатан суудал

Дд	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Санхүүжилт	Биелэлт	Биелэлтын хувь
1	2	3	4	5
<b>Арга хэмжээ 1. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах хүрээнд</b>				
1	Байгууллагын албан хаагчдыг цахим болон танхимын сургалтад хамруулж мэргэшүүлэх, чадавхижуулах давтан сургах ажлыг зохион байгуулах.	3748000	Байгууллагын албан хаагчдыг сургалтад хамруулж томилолтыг нь тухай бүр нь олгож байна 2025 онд 17 төрлийн сургалтад нийт 39 албан хаагч сургалтад хамрагдаж 3.748000 төгрөгний томилолт авсан байна. Баянхонгор аймаг болон Улаанбаатар хот явж сургалтад хамрагдсан.	90
2	Сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулж, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх.	Төсөв шаардахгүй	Засаг даргын Тамгын газарт гарсан 1 сул орон тоо тооны зарыг Аймгийн төрийн албаны зөвлөлд албан бичгээр хүсэлт хүргүүлэн зарлуулж ерөнхий болон тусгай шалгалтаар орон тоог нөхсөн.	100
3	Байгууллагын хүний нөөцийн системийн үйл ажиллагааг сайжруулж цаг тухай бүр нь шинэчлэлт хийж цалин бодох үйл ажиллагаанд саад учруулахгүй байх.	Төсөв шаардахгүй	Хүний нөөцийн системийг бүрэн шинэчилсэн холбогдох мэдээллийг үнэн зөв оруулсан. Өөрчлөлт орсон тухай бүр нь шинэчлэл хийж байна.	100
4	Байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг заавар журмын дагуу бүрдүүлж тухай бүр нь баяжилт хийх.	Төсөв шаардахгүй	Жилийн эцсийн байдлаар хувийн хэргийн бүрдэлд 20 албан хаагчдын хувийн хэрэг бүрдүүлэлт хийгдсэн. Тухай бүр нь баяжилт хийж байна.	90

1	2	3	4	5
<b>Арга хэмжээ 2. Албан хаагчдын ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог хангах хүрээнд</b>				
5	Албан хаагчдын ажлын үр дүн, төлөвлөгөөний гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлэн урамшуулах, нийт албан хаагчдын зэрэг дэв, цалингийн шатлалын болзол хангаж буй эсэхэд судалгаа хийж, болзол хангасан албан хаагчид тухай бүр олгох нөхөж олгох ажлыг зохион байгуулах.	Байгууллагын төсөв	Байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлыг сар бүр дүгнэн ур чадварын нэмэгдэлд 4,842,112 төгрөг зарцуулсан.	90
6	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу албан хаагчдад ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, ажлын шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй тохиолдолд нөхөн амруулах, мөнгөн урамшуулал олгох	Байгууллагын төсөв	Байгууллагын албан хаагчдын ээлжийн амралтыг Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 07-ны Б/05 тушаалаар олгон биеэр эдлүүлсэн.	100
8	Албан хаагчдын ажиллах нөхцөл хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй ажиллагааг хангах, өрөө тасалгааг тохижуулах.	Байгууллагын төсөв	Засгийн газрын хөрөнгө оруулалтаар Засаг даргын Тамгын газарт 18 ширхэг принтер, 11 ширхэг нөүтбүүк, 1 хурдны сканер ирсэн. Үүнийг нэн шаардлагатай байгаа албан хаагчдад өгч ажиллах нөхцөл боломжийг сайжруулав.	100

ХЯНАСАН  
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  Г МӨНХСҮХ  
 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН  
 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОПЕРАТОР ХҮНИЙ НӨӨЦ  
 ХАРИУЦСАН АЖИЛТАН  Б.ДЭЛГЭРМАА

